

## БАГШААС АВАХ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

### Танд энэ өдрийн мэндийг хүргэе!

**Санамж:** Энэхүү асуулгын зорилго нь дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн ажлын орчныг үнэлэхэд чиглэнэ. Судалгааны мэдээлэл нь зөвхөн сургуулийн үнэлгээний зорилгоор ашиглагдах тул энэхүү судалгаанд идэвхтэй оролцохыг танаас хичээнгүйлэн хүсье.

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Та асуултыг уншаад тохирох хариултыг сонгоно уу.

1. Таны нас ○ 25-с доош ○ 26-40 ○ 41-50 ○ 51-60 ○ 60-с дээш	2. Таны хүйс ○ Эрэгтэй ○ Эмэгтэй ○ Бусад	3. Таны боловсрол ○ Бакалавр ○ Магистр ○ Доктор
4. Таны албан тушаал ○ Профессор ○ Дэд профессор ○ Ахлах багш ○ Багш ○ Дадлагажигч багш	5. Та энэ сургуульд хэдэн жил ажиллаж байна вэ? ○ 1 хүртэл жил ○ 1-5 жил ○ 6-10 жил ○ 11-20 жил ○ 21-с дээш жил	

### II. ҮНДСЭН СУДАЛГАА

Та доорх асуулга бүртэй хэр санал нийлж байгаагаа 1-5 хүртэлх оноогоор үнэлж харалдаа мөр бүрд тохирох зөвхөн нэг хариултыг сонгоно уу. Санал огт нийлэхгүй-1, Санал нийлэхгүй-2, Зарим талаар санал нийлнэ-3, Санал нийлнэ-4, Санал бүрэн нийлнэ-5 оноо.

№	Асуулт	1	2	3	4	5
<b>2.1. Та сургуулийнхаа бодлого, удирдлагатай холбоотой зүйлсийн талаар эргэцүүлэн бодож тохирох хувилбарыг сонгоно уу.</b>						
1	Манай сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, бодлого, төлөвлөлт, дүрэм, журам тодорхой байдаг					
2	Би сургуулийнхаа бодлого, төлөвлөлт, дүрэм, журмын хэрэгжилтэд сэтгэл ханамжтай байдаг					
3	Би захирлуудын сургуулийг удирдаж буй ажлын арга барилд сэтгэл ханамжтай байдаг					
4	Би сургуулийн удирдлагын багийн харилцаа, хандлагад сэтгэл хангалуун байдаг					
5	Сургуулийн удирдлага шийдвэр гаргах үйл ажиллагаандаа багш нарын санал хүсэлт, оролцоог дэмжиж хамтран ажилладаг					
6	Сургуулийн удирдлагын зүгээс багш нарын гомдлыг хүлээн авч, шийдвэрлэж байгаа арга барилд сэтгэл ханамжтай байдаг					
7	Манай сургуулийн удирдлагууд олон улсын шилдэг их сургуулиудын сайн туршлага, дэвшилтэт арга барилаас үйл ажиллагаандаа байнга нэвтрүүлэн ажилладаг					
8	Багшийн шинэ сургалтын арга барил нэвтрүүлэх санал санаачилгыг сургуулийн удирдлага эергээр хандаж хүлээн авдаг					
<b>Та сургуулийнхаа гадаад дотоод орчин болон ажиллах нөхцөл боломжийн талаар эргэцүүлэн бодож хариулна уу.</b>						
9	Би сургуулийнхаа ажиллах орчин нөхцөлд (хичээлийн байр, анги танхим, халаалт, гэрэлтүүлэг, агааржуулалт гэх мэт) сэтгэл ханамжтай байдаг					
10	Цэвэрхэн, санаачилгатай, тав тухтай ажлын орчин нөхцөлийг бий болгож байгаад сэтгэл ханамжтай байдаг					
11	Сургалт явуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, материал, хэрэгслээр хангагдсан					
12	Хичээл заахад шаардлагатай ном сурах бичиг, бусад дагалдах					

	материаллаг хэрэглэгдэхүүнээр хангагдсан						
13	Хичээл сургалтын үйл ажиллагаа явуулахад тохиромжтой, тохилог анги танхим хүрэлцээтэй байдаг						
14	Сургуулийн анги танхим багш сурагчдад хүртээмжтэй, саадгүй (тусгай хэрэгцээт сурагчдад ээлтэй) байдаг						
15	Багш нарын амарч, чөлөөт цагаа зөв өнгөрөөх орчин нөхцөл, боломж (номын сан, спорт заал, амралтын өрөө) бүрдсэн байдаг						
<b>Та сургуулийнхаа удирдлага, хамт олны харилцаа хандлагын талаар эргэцүүлэн бодож тохирох хувилбарыг сонгоно уу.</b>							
16	Би сургуулийн удирдлага, багш, ажилчдын хоорондын харилцаа хандлагад сэтгэл хангалуун байдаг						
17	Би хамтран ажилладаг багш нарынхаа мэргэжлийн ур чадварт сэтгэл хангалуун байдаг						
18	Хамт олны уур амьсгал эерэг, бие биедээ ажлын урам зориг өгч, харилцан хүндэтгэлтэй ханддаг						
19	Сургуулийн удирдлагын зүгээс үзүүлж буй мэргэжлийн дэмжлэг, туслалцаанд сэтгэл хангалуун байдаг						
20	Сургуулийн удирдах ажилтнууд хичээл заах арга барил, ур чадварыг сайжруулах талаар зөвлөгөө өгдөг						
<b>Та өөрийнхөө цалин хөлс, шагнал, урамшуулал, тушаал дэвших боломжийн талаар эргэцүүлэн бодож тохирох хариултыг сонгоно уу.</b>							
<b>А) Цалин, хөлс, шагнал, урамшуулал</b>							
21	Би ур чадвар, хийсэн ажилдаа тохирсон цалин хөлс, шагнал, урамшуулал авдаг						
22	Би цалингаа цаг тухайд нь авч чаддаг						
23	Багш нар нэмэлт ажилдаа тохирсон нэмэлт урамшуулал авч чаддаг						
24	Сургуулийн удирдлага багш нарын нийгмийн асуудалд анхаарч ажилладаг						
<b>Б) Албан тушаал ахих боломж</b>							
25	Сургуулийн албан тушаал дэвших үйл явц, журам нь шударга ойлгомжтой, ил тод байдаг						
26	Багшийн ажил нь надад мэргэжил дээшлүүлэх, албан тушаал ахих боломжийг олгодог						
27	Багшийг мэргэжлийн хувьд хөгжих боломжийг тэгш хүртээмжтэй байдлаар бүрдүүлж чадсан						
<b>Ажлын ачаалал, чиг үүргийн хуваарилалтын талаар эргэцүүлэн бодож тохирох хариултыг сонгоно уу.</b>							
28	Багшийн ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргүүд оновчтой						
29	Албан тушаалын ангиллаас хамааруулан ажлын ачааллыг тэнцвэртэй шударга хуваарилдаг						
30	Удирдлагын зүгээс үндсэн чиг үүрэгт заасан ажлуудыг л хуваарилдаг						
31	Ажлын ачаалал нь миний хувьд ажил амьдралын тэнцвэртэй байдлыг хангаж чаддаг						
32	Ажлын байрны чиг үүрэгт заасан ажлыг гүйцэтгэхэд хялбар						
33	Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ үнэн зөв, шударга байдаг						
34	Цаг тооцох журам оновчтой, багшийн ажлыг бүгдийг хамарсан байдаг						

Бусад санал, хүсэлт:

БАТАЛГААЖИЛТ /Одоо барьж буй утасны дугаараа оруулна уу./: \_\_\_\_\_

Огноо: \_\_\_\_\_